


2019 оны 07 дугаар сарын 26-ны  
 өдрийн А/дугаар тушаалын 07.....  
 Хавсралт



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН  
 ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ХААГЧИЙН АЖЛЫГ  
 ДҮГНЭХ, УР ЧАДВАРЫГ ҮНЭЛЭХ ЖУРАМ

Төрийн үйлчилгээний ангилал зэрэглэлд хамаарах Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлыг дүгнэх, ур чадварын нэмэгдэл олгоход энэхүү журмыг мөрдөнө.

Хүн амыг бодлого, Хөдөлмөрийн яам, Сангийн сайдын 1996 оны 63/104 хамтарсан тушаалаар баталсан "Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын дагуу Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгоно.

Ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг "Ажилтны ажлыг дүгнэх, ур чадварыг үнэлэх үнэлгээний хуудас" -аар үнэлж, гүйцэтгэлийн болон ур чадварын нийлбэр үнэлгээ 80 онооноос дээш үнэлэгдсэн тохиолдолд ур чадвар нэмэгдлийг дараах хүснэгтийн дагуу албан хаагчийн албан тушаалын цалингийн 25 хувь хүртэл тооцож олгоно. Үүнд:

Гүйцэтгэл, ур чадварын нийлбэр үнэлгээ	95-100 оноо	90-95 оноо	85-90 оноо	80-85 оноо	80 доош оноо
Ур чадвар	25 хувь	20 хувь	15 хувь	10 хувь	Ур чадварын хувь нэмэгдэл тооцогдохгүй

Ажилтны ажлыг дүгнэх, ур чадварыг үнэлэх үнэлгээний хуудсын мягтаар 0-100 хүртэл оноогоор үнэлж дүгнэнэ.

Ажилтанд олгож байгаа ур чадварыг нэмэгдлийг нэмэгдүүлэх, бууруулах асуудлыг ажилтны ажлыг дүгнэх, ур чадварыг үнэлэх үнэлгээний хуудсаар дүгнэсний үндсэн дээр тухайн хэлтэс, тасгийн болон анхан шатны нэгж дээрх удирдах эрх бүхий албан тушаалтан шийдвэрлэнэ.

Захиргаа аж ахуйн албаны төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал зэрэглэлд хамаарах үйлчилгээний ажилтны ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, ур чадварыг захиргаа аж ахуйн албаны менежер, сургалтын албаны төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал зэрэглэлд хамаарах үйлчилгээний ажилтны ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, ур чадварыг сургалтын албаны менежер, албадын менежерийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, ур чадварыг захирал тус тус сар тутамд маягтын дагуу үнэлж дүгнэнэ.

Мөн бусад нэгж салбар үүсгэн байгуулагдсан тохиолдолд холбогдох зохион байгуулалтын дагуу үнэлж дүгнэнэ.

Үндсэн ажлын гүйцэтгэлд нөлөөлсөн шалтгаануудыг тодорхойлж, гүйцэтгэлийн үнэлгээ, ур чадварыг бодитоор үнэлнэ. Ур чадварын нэмэгдлийг ажилтнуудын цалинг нэмэх, амьдрал ахуйг харгалзах зэргээр хавтгайруулан олгохыг хориглоно.


- Дараах тохиолдолд ур чадварын нэмэгдлийн хэмжээг бууруулах буюу олгохгүй. Үүнд:
- Ажлын үр дүн буурсан
  - Сахилгын шийтгэлтэй бол
  - Ёс зүйн хорооны хурлаар буруутгагдан хэлэлцэгдсэн бол
  - Байгууллагын нэр хүнд илтэд унагах ёс бус үйлдэл гаргасан бол
  - Цагийн ирцийн мэдээний гүйцэтгэл хангалтгүй



Ажлын үр дүн, гүйцэтгэлд хангалтгүй үнэлгээ авсан албан хаагчид ажлаа сайжруулах анхааруулга өгөх, шаардлагатай тохиолдолд хариуцлага тооцох саналыг боловсруулж Захирлын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

Үнэлгээний маягтын дагуу үнэлж, сар бүрийн 22-ны дотор тооцооны нягтлан бодогчид ирүүлнэ. Дээрх заасан хугацаанд ажилтны ур чадварыг ирүүлээгүй тохиолдолд тухайн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдлийг олгохгүй. Ур чадварын нэмэгдлийг нөхөн олгохыг хориглоно.

Энэхүү журмыг 2019 оны 02-р сарын 01-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.



Ажилтны ажлыг дүгнэх, ур чадварыг үнэлэх үнэлгээний хуудас

Харъяалагдах алба хэлтэс.....  
 Ажилтны овог нэр.....  
 Албан тушаал.....  
 Тайлан сар.....

№	Шалгуур үзүүлэлт	Авбал зохих оноо	Авсан оноо	Тайлбар
1	Төлөвлөгөөт ажлын биелэлт	40		Тухайн албан хаагчийн сард хийж гүйцэтгэх, хийхээр төлөвлөсөн ажлаас хувь тэнцүүлэн тооцож олгоно.
2	Удирдлагаас өгсөн үндсэн бус үйл ажиллагааны биелэлт	20		Ажилтны үндсэн ажлаас бусад гүйцэтгүүлэхээр өгсөн үүрэг даалгаврыг биелүүлсэн байдлыг харгалзан үзэж олгоно.
3	Ажлын цаг ашиглалт	20		Сард 2-оос доошгүй хугацаан ХШУДА, Хүний нөөцийн ажилтан гэнэтийн ажлын байран дээрх цаг бүртгэлээр тооцон олгоно.
4	Олон нийтийн ажилд оролцон байдал	10		Байгууллагын зүгээс олон нийтийн ажил зохион байгуулах, тэмцээн уралдаан, хурал зөвлөгөөн гэх мэт тухайн сард хийгдсэн үйл ажиллагаанд оролцсон байдлыг хувь тэнцүүлэн олгоно.
5	Шинийг санаачилсан байдал	10		Өөрийн санаачилсан ажил үйлчилгээг гүйцэтгэсэн байдлыг харгалзан олгоно.
Нийт оноо			100	
Хувь тэнцүүлэн цалингаас бодож олгох				

Үнэлгээний хуудас дүгнэсэн албан тушаалтан:.....